



ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ



ГАРЫН АВЛАГА
2024 ОН

Тээврийн
хэрэгслийн
өмчлөгч, жолооч
нарт зориулав

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО



"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ГҮТББ НЬ

Даатгалын тухай хуулийн 12^{1.1} заасны дагуу албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, даатгалын сан болон мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, өргөжүүлэх, гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, даатгалын тохиолдлыг бууруулах, зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.



www.ami.mn

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ
ХУУДАСНААС АВАХ БОЛОМЖТОЙ

Агуулга

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ач холбогдол
- Жолоочийн хариуцлагын албан журмын болон сайн дурын даатгалын онцлог
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хэн хамрагдах вэ?
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд үл хамрагдах нөхцөл
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийг хэрхэн тооцдог вэ?
- Жолоочийн хариуцлагын албан журмынд даатгалын гэрээ байгуулахад анхаарах нь
- Даатгуулагчийн эрх, үүрэг
- Даатгагчийн эрх, үүрэг
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг цуцлах
- Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм
- Жолоочийн үүрэг
- Замын хөдөлгөөнд оролцогчоос бусад иргэн, хуулийн этгээдийн үүрэг
- Даатгалын тохиолдлын зам, тээврийн ослын үед авах арга хэмжээ
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөрийн олголтын талаар
- Албан журмын даатгагчдын холбооны Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр хүсэхэд бүрдүүлэх бичиг, баримт
- Цагдаагийн албаны тухай
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалгүй замын хөдөлгөөнд оролцсон тохиолдолд авах хуулийн арга хэмжээ
- Санал, гомдол
- Даатгалын компаниудын шуурхай алба

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын АЧ ХОЛБОГДОЛ

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаална.



**ЖОЛООЧИЙН
ХАРИУЦЛАГЫН АЛБАН
ЖУРМЫН ДААТГАЛ**



**САЙН ДУРЫН БУЮУ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ДААТГАЛ**

Хуульд заасны дагуу заавал даатгуулна.

Өөрийн буруугаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ. Жолоочийн нас, туршлага, тээврийн хэрэгслийн моторын багтаамж, нөхөн төлбөр авч байсан зэрэг итгэлцүүрээс хамаарч хураамжийн хэмжээг тогтооно.

Сайн дурын үндсэн дээр даатгуулна.

Өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгсэлд учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ. Тээврийн хэрэгслийн даатгалын үнэлгээ болон даатгалын учирч болзошгүй эрсдэл зэргээс хамааран хураамж тооцогдоно.

Жишээ нь:

Иргэн "А" нь тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын тээврийн хэрэгслийг гэмтээж хохирол учруулсан тохиолдолд гуравдагч этгээдэд учруулсан хохирлоо жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар нөхөн төлүүлнэ. Харин тээврийн хэрэгслийн сайн дурын даатгалд даатгуулсан нөхцөлд өөрийн авто машинд учирсан хохирлыг тээврийн хэрэгслийн даатгалын гэрээнд заасны дагуу барагдуулна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд

ХЭН

хамрагдах вэ?



Тээврийн
хэрэгслийн
өмчлөгч бүр,



Тээврийн хэрэгслийн өмчлөгчөөс үл
хамааран мэргэшсэн жолооч болон
C, D ангиллын тээврийн хэрэгслийн
жолооч нар заавал даатгуулна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд

ҮЛ ХАМРАГДАХ НӨХЦӨЛ

Монгол Улс гишүүнээр нь элсэн орсон Олон Улсын албан журмын даатгалын холбооны гишүүн орны даатгалын эрх бүхий байгууллагад даатгуулсан этгээд, Замын хөдөлгөөнд оролцдоггүй байлдааны тусгай зориулалттай болон мөрдөх алба, цагдаа, тагнуул, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын тээврийн хэрэгсэл,

Хохирогч нь энэ хуулиар тогтоосон даатгалын үнэлгээнээс давсан хохирлыг жолооч болон буруутай этгээдээс нэхэмжилсэн бол уг давсан хохирол, Захиргааны хариуцлага ногдуулах эрх бүхий этгээд нь албан үүргээ гүйцэтгэх үедээ Жолоочийн даатгалын болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж зөрчсөн жолоочийн тээврийн хэрэгслийг жолоодон төрийн байгууллагад хүргэх, зөөж, шилжүүлэхэд,

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын

ХУРААМЖИЙГ


хэрхэн тооцдог вэ?

“ Даатгалын компани бүр даатгалын хураамжийг тухайн тээврийн хэрэгслийн ангилал, зориулалт, даац, суудлын тоо, газарзүйн байршил мөн тээврийн хэрэгслийн өмчлөгч, үндсэн даатгуулагч болон хамтран даатгуулагч, жолоочийн туршлага, нөхөн төлбөр авсан түүх зэргээс хамаарах зарчмаар тооцдог

”

Даатгалын үнэлгээний хэмжээ, даатгалын хураамжийг Жолоочийн даатгалын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 9, 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу тооцогддог.

Таны төлөх хураамж...
суурь хураамж X итгэлцүүр



И1 Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршил

И2 Өмнөх гэрээний хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ

И3 Даатгуулагчийн нас, тээврийн хэрэгсэл жолоодох туршлага

И4 Даатгалын гэрээний хугацаа

И5 Даатгуулагч даатгалын хураамжийн хэмжээг журамд зааснаас доогуур тогтоосон, эсхүл даатгалын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн нь тогтоогдвол

И6 Тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тоо

И7 Тээврийн хэрэгслийн даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал

И8 Тээврийн хэрэгслийн зориулалт

И9 Чиргүүлтэй эсэх



(A) 12,500₮



(B) 33,000₮



(C) 42,500₮



(D) 53,000₮



(механизм) 12,500₮



Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ГЭРЭЭ БАЙГУУЛАХАД анхаарах нь

Гэрээ байгуулах даатгалын компаниа судалж сонгоно.

Даатгалын компанийг үнэн зөв мэдээллээр хангана. Гэрээний хураамж төлснөөр гэрээ хүчин төгөлдөр болно.

Даатгалын гэрээний хугацаа нэг жил байна.

Даатгалын гэрээг уншиж танилцсанаар баталгаажуулах. Даатгалын гэрээний нөхцөлтэй танилцах, мөн даатгалын компанийн ажилтнаас асууж тодруулах.

ДААТГУУЛАГЧ ТАНЫ ЭРХ, ҮҮРЭГ



Даатгуулагч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний талаар мэдээлэл авах, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээллийг шалгуулах.



Даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хэмжээгээр даатгагчид бүрэн төлөх



Даатгалын тохиолдол болсон үед шуурхай албаны үйлчилгээ авах, гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах.



Шаардлагатай баримт материалыг даатгагчид үнэн зөвөөр заасан хугацаанд бүрдүүлж, даатгагчид гаргаж өгөх



Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.4, ЖХАЖД-н гэрээний 7.2.3-т заасны дагуу даатгагч нь хуульд заасан хугацаанд даатгалын хохирол үнэлэгчийг томилоогүй бол даатгуулагч нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч этгээдэд хандах.



Зам тээврийн ослын үед ослын газраас хөдлөхгүйгээр даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, даатгалын гэрээг шалгуулах



Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулснаа хохирогчид мэдэгдэх



Даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөөр жолооч хохирогчтой тохиролцсон бол энэ тухайгаа даатгагчид мэдэгдэх

ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ



Даатгалын нөхөн төлбөрийг хууль, тогтоомж, гэрээнд зааснаар бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах,



Даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд даатгалын гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах,



Даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгалын үнэлгээний дүнгийн хэмжээнд багтаан учирсан хохирлыг олгох,



Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн мэдээллийн нууцыг задруулахгүй байх,



Даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгах зорилгоор даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх

ГЭРЭЭ ЦУЦЛАХ

Тээврийн хэрэгслийг бусдад зарсан болон шилжүүлсэн тохиолдолд даатгалын гэрээг болон даатгуулагчийн бичиг баримтын хамт даатгалын компани, түүний салбар нэгжээр цуцлуулна. Даатгалын гэрээний үлдэх хугацаатай тэнцэх хэмжээний даатгалын хураамжийг хувь тэнцүүлэн даатгуулагчид буцааж олгоно. Даатгалын гэрээний хугацаанд нөхөн төлбөр олгосон тохиолдолд даатгалын хураамжийн буцаалт хийгдэхгүй.

Монгол Улсын замын хөдөлгөөний ДҮРЭМ



**Жолоочийн
үүрэг**

Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч дараах бичиг баримттай байна. Үүнд:

Тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн хүчинтэй үнэмлэх буюу түр зөвшөөрөл (жолоодлогын дадлага хийж яваа суралцагчид хамаарахгүй);
Тухайн тээврийн хэрэгс-

лийн бүртгэлийн гэрчилгээ;
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын баталгаа;
Холбогдох хууль, эрхзүйнактад заасан ачааны болон бусад баримт бичиг;
«Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн» таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэл жолоодоход тулгуур эрхтний бэрхшээлтэйг нотлох бичиг баримт



Замын хөдөлгөөнд оролцогчоос бусад иргэн, хуулийн этгээдийн үүрэг:

Тээврийн хэрэгслийн өмчлөгч нь холбогдох хууль, журмын дагуу жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулсан байх үүргийг хүлээнэ.



Зам тээврийн ослын үед:

Хүний амьнас, эрүүл мэнд хохироогүй, осолд холбогдсон жолооч нарын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгөд хохирол учраагүй, ослоос үүдсэн эд хөрөнгийн хохирлыг жолооч, хохирогч нар өөр хоорондоо буюу даатгалын байгууллагатай харилцан маргаангүй шийдвэрлэхээр тохиролцсон бол цагдаагийн байгууллагад хандахгүйгээр шийдвэрлэх боломжтой.



Даатгалын тохиолдол, зам тээврийн ослын үед авах арга хэмжээ



1.

Өөрийн болон зорчигчдын эрүүл мэндийг нягтлах, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж дуудах.

Ослын тэмдэг байршуулах, даатгуулсан тухайгаа хохирогчид мэдэгдэх.

2.



3.

Даатгуулсан даатгалын компанид мэдэгдэх

Аль даатгалд даатгуулснаа мэдэхгүй, гэрээгээ олохгүй байгаа бол Албан журмын даатгагчдын холбооны 1800-1177 дугаарын утсанд холбогдох мөн Smartbox, Auto box, e-mongolia, ebarimt апплейкшн ашиглан шалгах боломжтой

4.

e mongolia



102

5.

Цагдаагийн байгууллагад мэдэгдэх

Даатгалын компаний ажилтны өгсөн зааварчилгааны дагуу холбогдох арга хэмжээг авч нөхөн төлбөрөө шийдвэрлүүлэх боломжтой.

6.





Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын **НӨХӨН ТӨЛБӨРИЙН** олголтын талаар

Даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд гэрээнд заасан даатгалын тохиолдолд нөхөн төлбөр олгоно. Даатгалын компаниас нөхөн төлбөр авахын тулд дараах баримт, материалыг бүрдүүлнэ.



- Даатгалын гэрээ
- Нөхөн төлбөр авахыг хүссэн өргөдөл
- Жолооны үнэмлэх, Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- Мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт
- Даатгалын хохирлын үнэлгээ
- Хэрэв банк болон банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан зээлээр авсан автомашин бол зээлийн гэрээний эх хувь
- Шаардлагатай тохиолдолд нэмэлт материал бүрдүүлнэ



- **Нөхөн төлбөр олгохгүй байх нөхцөл:**
- Санаатайгаар хохирол учруулсан
- Худал мэдээлэл өгч, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн
- Гарсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлсэн
- Гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй
- Бослого, үймээнд оролцсоны улмаас хохирол үүссэн
- Гэрээнд заасан хохирлын тохиолдлоос бусад нөхцөл



1800-1177

"Зам, тээврийн осол гаргасан даатгуулаагүй жолооч нь жолоочийн даатгалд даатгуулаагүй тухайгаа хохирогчид, Албан журмын даатгагчдын холбооны 1800-1177 болон цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ."

Албан журмын даатгагчдын холбооны Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгоход бүрдүүлэх бичиг, баримт:

ХОХИРОГЧ (хувь хүн)

1. Нөхөн төлбөр хүссэн өргөдөл
2. Иргэний үнэмлэхний хуулбар
3. Жолооны үнэмлэхний хуулбар
4. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
5. Хохирлыг үнэлсэн эрх бүхий байгууллагын дүгнэлт тайлан /эх хувь/
6. Хохирлын үнэлгээний байгууллагын үйлчилгээний хөлсийг төлсөн санхүүгийн баримт /и баримт/
7. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ
8. Шаардлагатай гэж үзвэл холбогдох нэмэлт баримт бичиг

ХОХИРОГЧ (хуулийн этгээд)

1. Албан тоот
2. Тухайн байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Тухайн үед жолоодож явсан жолоочийн өргөдөл
4. Жолоочийн иргэний үнэмлэхний хуулбар
5. Жолооны үнэмлэхний хуулбар
6. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
7. Хохирлыг үнэлсэн эрх бүхий байгууллагын дүгнэлт , хохирол үнэлгээний тайлан эх хувь
8. Хохирол үнэлгээний байгууллагын үйлчилгээний хөлсийг төлсөн санхүүгийн баримтын эх хувь
9. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ
10. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримт бичиг

БУРУУТАЙ ТАЛ

(хувь хүн)

1. Нөхөн төлбөр хүссэн өргөдөл /цээж зураг/
2. Иргэний үнэмлэхний хуулбар
3. Жолооны үнэмлэхний хуулбар
4. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
5. Оршин суугаа газрын тодорхойлолт
6. Замын цагдаагийн тодорхойлолт
7. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчсөний торгуулийг төлсөн баримт
8. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулсан байх уг даатгалын гэрээгээ авчрах
9. Бусад шаардлагатай нэмэлт баримт бичиг
10. Батлан даагчтай байх
11. Иргэний үнэмлэхний хуулбар
12. Ажлын газар, цалингийн тодорхойлолт
13. Нийгмийн даатгалын лавлагаа
14. Оршин суугаа хаягийн тодорхойлолт

БУРУУТАЙ ТАЛ

(хуулийн этгээд)

1. Албан тоот
2. Тухайн байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Тухайн үед жолоодож явсан жолоочийн өргөдөл
4. Жолоочийн иргэний үнэмлэхний хуулбар
5. Жолооны үнэмлэхний хуулбар
6. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
7. Тухайн байгууллагыг төлөөлж тус Холбоотой гэрээ байгуулах этгээдийг итгэмжилсэн итгэмжлэл
8. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчсөний торгуулийг төлсөн баримт
9. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулсан байх уг даатгалын гэрээгээ авчрах
10. Бусад шаардлагатай нэмэлт баримт бичиг

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ

Цагдаагийн алба хаагч улсын дугаар, бүртгэлийн зөрчилтэй, техникийн оношилгоо, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, эсхүл тээврийн хэрэгслийг түр саатуулж болно.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалгүй замын хөдөлгөөнд оролцсон тохиолдолд авах хуулийн арга хэмжээ

- Зөрчлийн тухай хуулийн 11.15 ын 7 дахь хэсэгт жолооч нь жолоочийн даатгалд даатгуулалгүйгээр тээврийн хэрэгслээ ашиглан замын хөдөлгөөнд оролцсон бол даатгалыг нөхөн төлүүлж хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлэх даатгалын 50 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- Зөрчлийн тухай хуулийн 14.7 ын 51 дэх хэсэгт жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчиж бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.





САНАЛ, ГОМДОЛ

Даатгалын тухай хуулийн 82.1-д Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Санхүүгийн Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ШУУРХАЙ АЛБА

| | | |
|---------------------------|-----|-----------|
| Амар даатгал | ХХК | 1800-2111 |
| Ард даатгал | ХК | 7720-0088 |
| Агула даатгал | ХХК | 7210-1010 |
| Ган зам даатгал | ХХК | 21-242667 |
| Бодь даатгал | ХК | 7000-4800 |
| Монгол даатгал | ХК | 1800-1990 |
| Мөнх даатгал | ХХК | 7599-1100 |
| Миг даатгал | ХХК | 7575-6000 |
| Монре даатгал | ХХК | 7777-9000 |
| Мандал даатгал | ХК | 7575-2000 |
| Номин даатгал | ХХК | 1800-2888 |
| Тэнгэр даатгал | ХХК | 1800-1889 |
| Хаан Даатгал | ХХК | 7000-0808 |
| Улаанбаатар хотын даатгал | ХХК | 7000-1234 |



АЛБАН ЖУРМЫН
ДААТГАГЧДЫН ХОЛБОО

Автомашины
эвдрэлийг 3
минутын дотор
хиймэл оюунаар
танин үнэлж
байна



 AGULA INSURANCE

 7210 1010



Mongol **GPT** 1.0

“АЛБАН ЖУРМЫН
ДААТГАГЧДЫН ХОЛБОО”
MONGOLGPT-Г ЧАТБОТДОО
НЭВТРҮҮЛЛЭЭ



www.mongolgpt.mn



АЛБАН ЖУРМЫН
ДААТГАГЧДЫН ХОЛБОО



ДААТГАЛ89



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ӨМЧЛӨГЧ

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛД

ДААТГУУЛААГҮЙ

ТОХИОЛДОЛД



ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД
ОРОЛЦОХ



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
ҮЗЛЭГТ ОРУУЛАХ



УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОНО.

 ЖДТХ-ИЙН 5.2. ЗААЛТ

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН
НЭГДСЭН ЛАВЛАХ



1800 1177



АЛБАН ЖУРМЫН
ДААТГАГЧДЫН
ХОЛБОО


УТСАА
БОЛЪЁ

ЛАВЛАХ: 1800-1177

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гар утас болон түүнтэй ижил төстэй төхөөрөмж, хэрэгслийг гарны оролцоотойгоор ашиглахыг хориглодог.

ЗХД-ийн 3.7 дахь заалт

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ,
СҮХБААТАР ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО, ГЭРЭГЭ
ТАУЭР 12-Р ДАВХАР



**1800-1177, 70101177,
70001277**



WWW.AMI.MN



INFO@AMI.MN



**Албан Журмын
Даатгагчдын Холбоо**